



ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН

ТУШААЛ

2022 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/165

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал А/185, А/252 дугаар тушаал, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн тасаг, албадын үйлчилгээний ажилтнуудын ажлын чиг үүргийг тодорхойлох, асрагч, үйлчлэгч, үйлчилгээний ажилтнуудын ажлын байрны зураг авалт хийж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Нарийн бичиг:

Гишүүд:

А.Цэрэндолгор (Захиргаа, хүний нөөцийн албаны дарга)

Б.Энхцацрал (ЗААлбаны ХАБЭАХМэргэжилтэн)

П.Энхболд (ЗХНАлбаны менежер)

Т.Номинтуяа (ЗХНАлбаны менежер)

Т.Сүхболд (ХСХАлбаны дарга)

Г.Оюун-Эрдэнэ (ХСХАлбаны тархвар судлаач)

Б.Бүрэнжаргал (ХСХАлбаны ахлах сувилагч)

2. Асрагч, үйлчлэгч, үйлчилгээний ажилтнуудын ажлын байрны зураг авалт хийх ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Ажлын байрны зураг авалтыг 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн дотор хийн, санал дүгнэлт боловсруулж, 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн дотор Гэмтэл Согог Судлалын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (А.Цэрэндолгор)-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Э.ГАЛБАДРАХ

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн
Ерөнхий захирлын 2022 оны 11 сарын 30-ны
..... А/165 дугаар тушаалын хавсралт

ГЭМТЭЛ СОГОГ
СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

**Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн асрагч, үйлчлэгч, үйлчилгээний
ажилтнуудын ажлын байрны зураг авалт хийх ажлын хэсгийн удирдамж**

ЗОРИЛГО:

Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн асрагч, үйлчлэгч ажилтнуудын ажлын чиг үүргийг тодорхойлох, ажлын байрны зураг авалт хийх, ажлын цаг зарцуулалт, ажлын ачааллыг тодорхойлоход оршино.

ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛБЭР:

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуваарь бүхий тасаг, нэгж дээр газар дээр нь очиж ажиллана. Ажлын байрны зураг авалтыг дараах байдлаар хийнэ. Үүнд:

- Ажиглалтын арга: ажил үйлчилгээ хэрхэн явагдаж буйг бодит байдал дээр ажиглан, ажлын цаг зарцуулалт болон албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй сул зогсолтын хугацааг хэмжиж, бичилтийг дэлгэрэнгүй, дараалуулан хийх, тэмдэглэл хөтлөх байдлаар хийнэ.
- Асуулгын арга: ажил үйлчилгээний талаар ажлын байранд ажилтнуудаас асууж, тодруулах байдлаар хийнэ.
- Дүн шинжилгээний арга: бүтэц, орон тоо, албан тушаалын тодорхойлолтыг шинжлэн, судлах байдлаар хийнэ.

АЖЛЫН ЗУРАГ АВАЛТ ХИЙХ ХУГАЦАА:

Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн асрагч, үйлчлэгч ажилтнуудын ажлын зураг авалтыг 2022 оны 12 дугаар сарын 01-09-ний өдрүүдэд хийнэ.

ЗУРАГ АВАЛТ ХИЙХ АЖЛЫН ЧИГЛЭЛ:

- Зохион байгуулалтын бүтэц, орон тоо нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх;
- Батлагдсан орон тоон дээр ажиллаж байгаа хүмүүсийн чиг үүргийг тодорхойлох;
- Ажлын цаг зарцуулалт;
- Ажилтнуудын ажлын ачааллыг тодорхойлох,
- Тухайн албан тушаалд ажиллаж байгаа хүмүүс нь тэдгээрийн ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох.

АЖЛЫН ХЭСГИЙН ТАЙЛАГНАЛ:

Ажлын байрны зураг авалтад хамрагдсан тасаг, алба тус бүрээр илтгэх хуудас бичиж, дүгнэлт саналаа 2022 оны 12 дугаар сарын 14-ний дотор Гэмтэл Согог Судлалын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулна.